



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулж,  
сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 3.27.1 дэх заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.6, "Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны төлбөртэй дотоод сургалтын төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дашваанжил" ХХК-ийн Газ эдүкэйшн сургалтын төвд 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр танхимаар зохион байгуулах "Шингэрүүлсэн шатдаг хийн түлшний тоног төхөөрөмжийн операторчны сургалт"-д "Буян-Ухаа" Олон улсын нисэх буудлын Аэродромын хэсгийн хавсралтад нэр дурдсан ажилтнуудыг хамруулсугай.

2. Сургалтын төлбөр 765,000 (долоон зуун жаран таван мянга) төгрөгийг зохих журмын дагуу олгохыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т зөвшөөрсүгэй.

3. Сургалтын хөтөлбөрийг бүрэн хангаж 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн дотор тайлагнахыг суралцагч нарт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Нисэхийн сургалтын төв (Б.Урантөгс)-д тус тус үүрэг болгосугай.

4. Сургалтад амжилтгүй хамрагдсан ажилтнуудаас сургалтын төлбөрийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг "Буянт-Ухаа" Олон улсын нисэх буудал (Л.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.БАТСАЙХАН

1723 01 0412

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын  
2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн  
А/С.Т. дугаар тушаалын хавсралт



### СУРГАЛТАД ХАМРАГДАХ АЖИЛТНУУДЫН НЭРС

№	Нэрс	Албан тушаал
1.	Ц.Шижир-Эрдэнэ	Ахлах инженер
2.	Э.Энхцэцэг	Ашиглалтын инженер
3.	Д.Пүрэвдорж	Ашиглалтын инженер
4.	А.Баттогтох	Механик инженер
5.	Ж.Дэлгэрмөрөн	Орнитологич инженер
6.	Д.Заяа	Орнитологич инженер
7.	Г.Рэнчиндорж	Ажилчин-шувуу үргээгч
8.	М.Содномдорж	Техникч
9.	С.Ганзориг	Гагнуурчин, цахилгаанчин
10.	Б.Уламбаяр	Зам талбайн үйлчлэгч механик
11.	Б.Энхбат	Зам талбайн үйлчлэгч механик
12.	М.Магсаржав	Зам талбайн үйлчлэгч
13.	С.Ганбаяр	Зам талбайн үйлчлэгч
14.	Г.Отгонбаяр	Зам талбайн үйлчлэгч
15.	Б.Саруул	Зам талбайн үйлчлэгч
16.	Ж.Алтанхуяг	Зам талбайн үйлчлэгч
17.	Ж.Цогбадрах	Ажилчин-жижүүр

--- оОо ---